

## СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

О. Оюунгэрэл

**ЯПОН ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛЫН ТОЙМООС**

Японд монголын судлал нэлээд дээр үеэс эхэлсэн боловч БНМАУ-ын социалист байгуулалтын ололт амжилтыг үнэн зөвөөр судалсан нь маш ховор бөгөөд энэ ажилд хожуу оржээ. Д-р Нака Цусэй 1907 онд Монголын Нууц товчоог орчуулж «Чингэс хааны үнэн тэмдэглэл» гэсэн нэртэйгээр хэвлэн гаргасан нь Япон дахь Монгол судлалын эх үүсвэр болсон байна. 1900-1931 он хүртэл Япон дахь монгол судлал түүх, утга зохиол, хэл шинжлэлийн чиглэлээр дагнаж байв. Монголын судлалыг Японд эхэлж хөгжүүлсэн ууган эрдэмтдийн нэг бол Японы монголч эрдэмтэн Нака Цусэй юм. Тэрээр хятад хэлнээс «Монголын нууц товчоо»-г анх удаа хуучин япон хэлэнд буулган орчуулжээ. Японы эрдэмтэд дотроос Тории, Рюдзо, Сиратори Куракити нар монголын эртний түүх, архелогийг судлах ажилд гол анхаарлаа тавьсан ажээ.

Археологич Тории Рюдзо 1910 оны үед Өвөр Монголын нутгаар аялж монголчуудын аж амьдрал, зан заншлын тухай ном бичжээ. Мөн түүхч Сиратори Куракити монголын эртний, дундат үеийн түүх судлалаар нилээд дорвилог бүтээл гаргасан бөгөөд монгол хэл, түүний дотроос эртний монгол аймгуудын хэлийг судлах талаар нилээд амжилт гаргажээ.

Японд монгол хэлний судлалыг 1910-аад оны үеэс эхлэн хөгжүүлж 1914 онд Токиогийн гадаад хэлний тусгай сургууль (Одоогийн Токио-гийн гадаад хэлний дээд сургууль), 1920 онд Осака хотын гадаад хэлний дээд сургуульд тус тус монгол хэлний салбар анги байгуулж эхэн үедээ 3-6 оюутан элсүүлэн сургаж байжээ. Одоо дээрх хоёр дээд сургууль жил бүр 15 оюутан элсүүлэн сургаж байгаа бөгөөд нийтдээ 120 гаруй оюутан монгол хэл сурч байна. Үүнээс гадна хэд хэдэн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд монгол судлалын боловсон хүчнийг бэлтгэдэг байна.

1931-1945 онд монголын судлалыг японы эрдэмтэд их анхаарч монголын тухай бичсэн ном зохиол элбэгшжээ. 1900-1950 оны хооронд японы монголч эрдэмтэн нар монголын түүх, соёл, урлаг, хэл зохиол, шашин, угсаатны зүй зэрэг судалгааны талаар 160-аад ном, 2050 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичжээ.

Гэвч энэ нь Японы милитаристуудын эзлэн түрэмгийлэх бодлоготой шууд холбоотой гарч ирсэн болохыг анхаарах нь зүйтэй юм. Тэд Монголын судлалын ажлыг эрдэм шинжилгээний байгууллагын шугамаар зохиож байснаас гадна «Дзэнрин кёкай», «Кёвакай», «Мантэцу» гэх зэрэг японы нууц албаны хавсрага газруудаар дамжуулан зохиож байв. Эдгээр салбарууд нь тэр үеийн Өвөр Монголын засаг захиргааны бүх шатны байгууллагын дэргэд ажиллаж байв. Үүнээс гадна Японы хуурай замын цэргийн жанжин штабын удирдлагын дор Монголыг судалж байв. «Дзэнрин кёкай»-ийн хэвлэлийн газраас «Моко» (Монгол) хэмээх сэтгүүл 1945 оны дайн дуустал гаргаж түүндээ БНМАУ-ын улс төр, эдийн засаг, гадаад дотоод байдлын талаар тогтмол мэдээлэн бичиж,

зарим үед социалист БНМАУ-ын гадаад дотоод бодлого, Монгол-Зөвлөлтийн найрамдлын талаар янз бүрийн гүтгэлгийг ч дэгдээж байв. Тухайн үед Юда Намио, Ивамура Синобу, Эноки Кадзо, Исида Микиноскэ, Мураками Масацуку, Сагути Тоору, Кобаяси Косиро, Симонага Кэндзи, Судзуэ Мантаро, Идэмура Рёити, Хаттори Сиро, Кодзима Такэо, Абэмацу Гэнъити, Номура Масаёси зэрэг эрдэмтэд монгол судлалаар нилээд зүйлийг бүтээжээ. Проф. Ивамура Сииобу 50 орчим жил монголын судлалаар ажиллахдаа Юан гүрний үеийн нийгэм, эдийн засгийн асуудлуудыг нарийвчлан судалж, 1968 онд «Монголын нийгэм эдийн засгийн түүхийн судлал» гэсэн томоохон зохиол бичжээ. Проф. Хаттори Сиро Токиогийн гадаад хэлний сургуулийн монгол хэлний ангийг төгсөж гарснаас хойш монгол хэл судлах талаар их ажил хийжээ. Түүний бичсэн 5 ном, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл дотроос «Хэл шинжлэлийн арга», «Авиалбар ба зөв бичих дүрэм», «Авианзүй», «Алтайн хэлнүүд» гэдэг чамбай бүтээлүүд нь монгол хэл шинжлэлийн санд зохих хувь нэмэр оруулжээ. С. Хаттори «Нууц товчоо»-нд монгол үгийг илэрхийлж байгаа хятад үсгийн авиан зүйн тухай гэдэг эрдэм шинжилгээний томоохон өгүүлэл бичжээ.

Осака хотын гадаад хэлний дээд сургуулийн хүндэт проф. Абэмацу Гэнъити монгол хэлийг монголын Юан гүрэн (1268--1368), хятадын Мин (1368-1644) улсын үеийнхээс эхлэн орчин үеийн монгол хэл хүртэл судалж эрдэм шинжилгээний томоохон бүтээлүүд туурвисанаас гадна 1958 онд «Монгол Япон шинэ үсгийн толь» зохиосон нь монгол хэл сурч байгаа япон хүмүүсийн ширээний ном болжээ.

Проф. Кобаяси Такасиро «Нууц товчоо», «Алтан товч»-ийг япон хэлнээ орчуулжээ. Мөн Юан гүрний хуулийн систем зэрэг XIII зууны Монголын түүхийн тухай хэд хэдэн бүтээл туурвиснаас гадна монголын эртний соёл, угсаатны зүй, зан заншил, монголчуудын нийгмийн байгуулалтын талаар судалгааны нэлээд ажил хийжээ. Симонага Кэндзи, Судзуэ Мантаро нар 1933 онд «Монгол хэлний их толь», Идэмура Рёити 1934 онд «Монгол хэлний тухай» зэрэг өгүүлэл бичиж нийтлүүлсэн ба проф. Кодзима Такэо 1938 онд «Монгол хэлний дүрэм» бичсэн байна.

Японы түүхчид ихэвчлэн хятад сурвалж бичгийн мэдээ сэлт мөн тухайн үед Өвөр Монголоос олсон монголын түүхийн материалд тулгуурлан Монгол судлалын ажлыг дүгнэж байсан нь нийт монголчууд ялангуяа БНМАУ-ын түүхийг гуйвуулах байдалд хүргэжээ.

Дайны дараах (1945 оноос хойших) жилүүдээс эхлэн Японд Монголын түүх, хэл судлалаас гадна БНМАУ-ын соёл урлаг, угсаатны зүй археологи зэргийг судлан хөгжүүлэх ажил хөгжжээ. 50-иад оноос эхлэн японы зарим монголч эрдэмтэд БНМАУ-д ирэх болж 1959 онд Улаанбаатарт хуралдсан монголч эрдэмтэдийн анхдугаар их хуралд Абэмацу Гэнъити, Одзава Сигэо, Ивамура Синобу нар оролцжээ.

40-өөд оноос хойш Монгол судлалаар Японд гарсан томоохон бүтээл гэвэл Мураяма Ситирогийн «Дундад зууны үеийн монгол хэл», «Кидан үсэг уншиж тайлах тухай», Сакамото Корэтадагийн «Монгол хэлний шинэ үсгийн дүрэм», «Монголын өнөөгийн байдал», проф. Одзава Сигэо монгол хэл, голчлон дундад зууны монгол хэлийг судлан «Монгол хэлэн дэх үг, үегийн асуудал», «Дундад зууны үеийн монгол хэлний морфем», «Монгол хэл ба япон хэл», «Нууц товчоон дахь монгол хэлний талаархи судалгаа» зэрэг судалгааны чанартай 15 ном, олон арван өгүүлэл бичсэнээс гадна Монголын уран зохиолоос «Далан худалч», «Зам» зэрэг уран зохиолыг монголоос япон хэлнээ хэвлүүлжээ. Осака хотын гадаад хэлний дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч проф. Араи Синъити «Монгол-япон хэл шинжлэлийн нэр томъёо» гэсэн эмхтгэл

гаргаж, проф, Танака Кацухико өөрийн судалгааг хэл зүй, уран зохиол, «Гэсэрийн тууж»-аас эхэлж «Монголын орчин үеийн түүх ба түүхийн материал», «Хатанбаатар Магсаржав», мөн 1971 онд Монгол ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулж «Тал нутаг ба хувьсгал» зэрэг ном бичсэнээс гадна Х. Чойбалсангийн «МАХН-ын товч түүх», Бадамхатан «Хөвсгөлийн цаатны амьдрал» зэрэг номыг япон хэлнээ орчуулжээ.

Японы монголч эрдэмтэд монголын түүхээс ихэвчлэн хүй нэгдлийн байгуулал, феодалын түрүү болон Юан гүрний нийгэм эдийн засгийн хөгжил болон тэр үеийн худалдаа наймааны ажил, мөнгөн гүйлгээ, төрийн бодлого, засаг захиргааны байгуулалтын талаар нэлээд зохиол бичсэн болох нь эрдэмтэн Нива Томосабуро, Отаги Мацуо, Симада Масао Утида Гимпу нарын нэлээд бүтээлээс харагдаж байна. Сүүлийн үед Японы эрдэмгэд монгол судлалын ажилдаа орос, зөвлөлтийн болон гадаадын жуулчид, газар зүйч, археологич нарын олон арван бүтээл, тэмдэглэлийг өөрийн хэлнээ орчуулан ашиглаж байна. Үүнд: Марко Поло, Плано Карпини нарын замын тэмдэглэлүүд, О. Латтиморын «Монгол улс» (нүүдэлчин ард түмэн), А. П. Окладниковын «Алс Дорнодын район ард түмний соёлын үүсвэр», «Элсэн цөлийн таавар» зэрэг бүтээлийг япон хэлээр орчуулан хэвлэжээ.

Монголын нүүдэлчин ард түмний нийгэм соёл, түүний онцлог шинж чанар мал аж ахуйн хөгжлийн талаар эрдэмтэн Ито Коити 1950-60 онд эрдэм шинжилгээний нэлээд зохиол бичжээ. Ивамура Синобу, Кобаяси 7 акасио нар Юан гүрний үеийн хууль цааз, Ногами Синдзё, Оябу Масая нар монголын шашныг голчлон судалж, Касуга Рэйти «Монгол дахь буддын шашны байдлын судалгаа», Канаока Хидэтомо «Монголын буддын шашны онцлог чанар» зэрэг ном, өгүүлэл бичжээ.

1900-1970 онд Японд гарсан Монголын судлалын нэгэн сэдэвт зохиол, тусгай шинжилгээний том жижиг өгүүлэл асар олон байдаг бөгөөд тэр бүрийг тоймлон бичих боломжгүй учир тэдгээр зохиолын зөвхөн ерөнхий төрх байдлыг тэмдэглэсэн болно.

1972 онд БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтсон нь тус хоёр орны хооронд соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой болов.

1971 онд Японы «монголч эрдэмтэдийн нийгэмлэг» байгуулагдаж Монгол судлалын цар хүрээг нэлээд их болгох хандлагатай ажиллаж эхлэв. 70-аад оноос японд монгол судлаачдын тоо нэлээд олширч эхлэв. Осака хотын гадаад хэлний дээд сургуулийн багш Онуки Масао орчин үеийн монголын түүхийг судалж байна. Токиогийн гадаад хэлвий дээд сургуулийн багш Хасуми Харуэ «Нууц товчоо»-г ардын аман зохиолын талаас судалж байгаагийн зэрэгцээ «Монголын ардын үлгэрийн орчуулга ба судлал» хэмээх судалгааны ном бичжээ. Цукуба их сургуулийн багш Дзё Хакутаро монгол хэлний авиан зүйг судалж байна.

Мөн БНМАУ-ын нэн шинэ түүхийн асуудлаар эрдэм шинжилгээний хялбарчилсан хэд хэдэн зохиол хэвлэгдсэн байна. Сүүлийн үед БНМАУ-ын нэн шинэ түүх, эдийн засгийн хөгжлийн асуудлаар японы монголч эрдэмтэд нэлээд тооны зохиолыг манай улсын шинэ тоо, баримт сэлтэд тулгуурлан тус орны социалист хөгжлийн замыг объектив үзлийн үүднээс бичиж байгааг тэмдэглүүштэй байна.

Васэда их сургуулийн багш Ёсида Кадзутоси монголын түүх, Азийн их сургуулийн багш Кои Гэути монголын эдийн засаг зэргийг судалж байна. Окаяма хотын их сургуулийн хөдөө аж ахуйн факультетийн декан, проф. Нагахара Киндзо БНМАУ-ын газрын ашиглалт, усжуулалт, тариалангийн талбайн хамгаалалт, өвс ургамлын шинж төрийг нэгтгэн судалж байна. Проф. Накаэ Тоситака монголын цагаан идээг шинжлэн судалгаа хийжээ.

Киото, Осака хотуудын их сургуулиудад монгол дахь шарын шашин, үндэсний урлаг, хөгжим зэргийг судалжээ. Үүнээс гадна япон хэлнээ Ю- Цэдэнбалын зохиолын түүвэрүүд «Социалист Монголын хөгжил дэвшлийн түүхэн замнал», «Социалист Монголын өнөө, маргааш», МАХН-ын XVII их хурлын материалын эмхтгэл, мөн «Монголын шилдэг яруу найраг» зэрэг ном орчуулж гаргав. Энэ бүхнээс үзэхэд Японы монголч эрдэмтэд Монгол судлалын талаар багагүй зүйл хийж, сонирхож байгаа нь тодорхой байна.

## О МОНГОЛОВЕДЕНИИ В ЯПОНИИ

### Резюме

Монголоведение в Японии начало развиваться сравнительно давнопервые исследования относятся к началу нынешнего столетия. Начинателем монголоведения в Японии считается ученый-монговед Нака Цусэй, который впервые перевел с китайского на старояпонский язык монгольское «Сокровенное сказание».

Дальнейшее свое развитие монголоведение в Японии получает с 1-ой четверти XX века. В это время такие ученые как Тории Рюдзо, Сиратори Куракити и другие уделяют внимание изучению древней истории Монголии.

Исследование по монгольской лингвистике начинается с 1910-х годов, когда в 1914 г при Токийском, а в 1920-м году при Осацком Институтах иностранных языков создаются учебный факультет и отделени монгольского языка.

С 1931-1945 гг. значительно увеличилось издание книг и литературы по Монголии, что было связано главным образом с политикой японских милитаристов в отношении МНР. Работы японских авторов данного периода характеризуются тенденциозностью и во многих случаях враждебностью к независимому существованию монгольского народа. Примером тому может служить периодический журнал «Монголия» (Моко), который выпускался военным издательством «Дзэнрин кёкай» вплоть до 1945 года.

Начиная с послевоенного периода, кроме исследований истории, языка и литературы, японские авторы интересуются вопросами современного развития МНР. Начали появляться переводы трудов монгольских ученых и писателей. В частности, сборник тов. Ю.Цеденбала «Исторический путь развития социалистической Монголии» (1978 г), «Сегодня и завтра социалистической Монголии» (1976 г), а также «Материалы XVII съезда МНРП» и другие.

С 1900-1950 гг. японскими учёными-монголоведами написано более 160 книг, 2050 научно-исследовательских статей по Монголии.